

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

| | |
|---|----|
| Агуулга..... | 1 |
| 1. Аудитын гэрчилгээ | 2 |
| 2. Аудитын тайлан | 4 |
| 2.1. Оршил | 4 |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 4 |
| 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 4 |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 5 |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 5 |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 5 |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 6 |
| 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд | 6 |
| 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга..... | 6 |
| 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн..... | 7 |
| 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 7 |
| 2.12. Шилэн дансны мэдээлэл..... | 7 |
| 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт | 7 |
| 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл..... | 7 |
| 3. Менежментийн захидал..... | 8 |
| 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан..... | 9 |
| 4.1 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан..... | 9 |
| 4.2 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 10 |
| 4.3 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 11 |
| 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт | 12 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| НБББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| ХХК | Хязгаарлагдмал Хариуцлагатай компани |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ИНСТИТУТИЙН
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ
САНГИЙН ЗАХИРАЛ М.АЛТАНСҮХ
ТАНАА

2020.02.27 № 06/622
танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр нийгмийн хамгааллын институтийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөлмөр нийгмийн хамгааллын институтийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөлмөр нийгмийн хамгааллын институтийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус Улсын хүүхэлдэйн театрт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн шууд захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хөдөлмөр нийгмийн хамгааллын институтын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус институтын захирал М.Алтансүх Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгох, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр нийгмийн хамгааллын институтын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын институтын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 30-наас 2020 оны 02 дугаар сарын 19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Сүлд-Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын институтын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/09 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хөдөлмөр нийгмийн хамгааллын институтын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь төрөөс хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, хөтөлбөрийн суурь судалгаа шинжилгээ, хэтийн болон ойрын тооцоолол хийж, зөвлөмж, чиг үүргийг боловсруулахад оршино.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын институтын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа
- Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа
- Цалин хөлсний бүтцийн судалгаа гэсэн судалгаануудыг хийх

Хөдөлмөр нийгмийн хамгааллын институтын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого журмын хүрээнд төсөв, санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэдэг. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын институтын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Explorer 3.5.2 програм хангамж ашигладаг байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын институтын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хөдөлмөр нийгмийн хамгааллын институтын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 243,120.0 мянган төгрөгөөс тооцон 2,431.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 3,282.2 мянган төгрөгөөр тооцсон нь нийт зардлын дүн 328,224.0 мянган төгрөг зарцуулсантай холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хөдөлмөр нийгмийн хамгааллын институтын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос өөрчлөлт гараагүй байна.

Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт байхгүй.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 4 хөтөлбөрт зориулан 328,224.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,454.0 мянган төгрөгийг суртчилгаа, олон нийтийн арга хэмжээ, хөдөлмөрийн яармаг, өдөрлөг зохион байгуулах, хууль тогтоомж, эрх зүйн актын уулзалт хэлэлцүүлгийн зардалд, 5,000.0 мянган төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээ, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс хөндлөнгийн үнэлгээ хийх зардалд, 311,150.0 мянган төгрөгийг Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн судалгааны зардалд, 10,620.0 мянган төгрөгийг Гарын авлага, хэвлэмэл материал бэлтгэх хэвлүүлэх зардалд тус тус зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 328,224.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттөй уялдуулан авч үзэхэд дараах байдалтай байна. Тухайлбал: Нийт 328,224.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,453.8 мянган төгрөгийг Суртчилгаа, олон нийтийн арга хэмжээ, хөдөлмөрийн яармаг, өдөрлөг зохион байгуулах, хууль тогтоомж, эрх зүйн актын уулзалт хэлэлцүүлгийн зардалд, 4,162.6 мянган төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээ, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс судалгааны зардалд, 212,790.8 мянган төгрөгийг Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн судалгааны зардалд, 10,589.0 мянган төгрөгийг Гарын авлага, хэвлэмэл материал бэлтгэх хэвлүүлэх зардалд, нийт 228,996.2 мянган төгрөгийн зардал тус тус гарч, 99,227.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 эрсдэл тодорхойлж гүйцэтгэх үе шатанд 13 эрсдэл тодорхойлж нийт 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хөдөлмөр нийгмийн хамгааллын институтын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 7 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөдөлмөр нийгмийн хамгааллын институтын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хөдөлмөр нийгмийн хамгааллын институтын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 зүйлийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 НБББББ-тэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын судалгааны институтийн захирлын 2017 оны А/1 тоот тушаалаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж үйл ажиллагаандаа мөрдсөн боловч тухайн сангийн үйл ажиллагаанд нийцэхгүй, сайжруулах шаардлагатай байгаа нь Үнэлгээ, Үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж: Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын судалгааны институт нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж үйл ажиллагаандаа мөрдсөн боловч тухайн сангийн үйл ажиллагаанд нийцэх үүднээс ХЭДСангийн зарцуулалтын талаар зарим заалтыг оруулан, сайжруулах шаардлагатай байна.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 243,120,000.00 | 328,224,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 243,120,000.00 | 328,224,000.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 243,120,000.00 | 328,224,000.00 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | 243,120,000.00 | 328,224,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 243,120,000.00 | 328,224,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 243,120,000.00 | 328,224,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 243,120,000.00 | 328,224,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 242,995,558.00 | 228,996,207.40 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 242,995,558.00 | 228,996,207.40 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 124,442.00 | 99,227,792.60 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 124,442.00 | 99,227,792.60 |

4.2 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 243,120,000.00 | 328,224,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 243,120,000.00 | 328,224,000.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 243,120,000.00 | 328,224,000.00 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | 243,120,000.00 | 328,224,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 243,120,000.00 | 328,224,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 243,120,000.00 | 328,224,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 243,120,000.00 | 328,224,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 242,995,558.00 | 228,996,207.40 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 242,995,558.00 | 228,996,207.40 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 124,442.00 | 99,227,792.60 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 124,442.00 | 99,227,792.60 |

4.3 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| ЭЗА | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--------|--|-----------------------|----------------|-----------------|------|
| | ХАРИЛЦАХЫН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 328,224,000.00 | 228,996,207.40 | (99,227,792.60) | 30.2 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 328,224,000.00 | 228,996,207.40 | (99,227,792.60) | 30.2 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 328,224,000.00 | 228,996,207.40 | (99,227,792.60) | 30.2 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 10,620,000.00 | 10,589,000.00 | (31,000.00) | 0.3 |
| 210404 | Ном, хэвлэл | 10,620,000.00 | 10,589,000.00 | (31,000.00) | 0.3 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 316,150,000.00 | 216,953,407.40 | (99,196,592.60) | 31.4 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 311,150,000.00 | 212,790,847.40 | (98,359,152.60) | 31.6 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,000,000.00 | 4,162,560.00 | (837,440.00) | 16.7 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,454,000.00 | 1,453,800.00 | (200.00) | 0.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,454,000.00 | 1,453,800.00 | (200.00) | 0.0 |
| 131006 | ЗАРДЛЫН САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 328,224,000.00 | 228,996,207.40 | (99,227,792.60) | |
| 131006 | ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГААС САНХҮҮЖҮҮЛЭХ | 328,224,000.00 | 228,996,207.40 | (99,227,792.60) | |
| | ХАРИЛЦАХЫН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ | | | | |

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|------------------------------|---|--|----------------------|
| Огноо: | Аудитын нэр: | Хөдөлмөр нийгмийн хамгааллын институтийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны жилийн | Аудитын код |
| 2019 | | | САГ-2020/169/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Хөдөлмөр нийгмийн хамгааллын институтийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|------------|---------------------------------------|---|--------------|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын судалгааны захирлын 2017 оны А/1 тоот тушаалаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж үйл ажиллагаандаа мөрдсөн боловч тухайн сангийн үйл ажиллагаанд нийцэхгүй, сайжруулах шаардлагатай | - | Зөвлөмж өгөх | Нягтлан бодогч | Б.Пүрэвцэцэг |
| | Нийт | - | | | |

